



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/21

Мандалговь

「 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай
хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2, 8 дугаар зүйлийн 8.1, 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.9, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 04/2020 албан бичиг, Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 01/1858 дугаартай албан бичиг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 01/744 дугаартай албан бичгийг тус тус үдэслэн ТУШААХ нь:

1. Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод байлгах үйл ажиллагааг зохион байгуулсугай.

2. Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг 1 дүгээр, үйл ажиллагаанд шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 1,050,000 (Нэг сая тавин мянга) төгрөгийн зардлыг Нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Залуучуудын салбар зөвлөл хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн (Д.Мигар), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд Залуучуудын салбар зөвлөл хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн (Д.Мигар), -д даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482301041

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 10 ний өдрийн
#41 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д. Мигар

(Залуучуудын салбар зөвлөл хамтын
ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичиг:

Б. Бүжинлхам

(Захиргаа хүний нөөц хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Биндэръяа

(Архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан)

---oOo---

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 03 дүгээр сарын 09-ны өдрийн
А/А тоот тушаалын А дугаар хавсралт



ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ашиглалт үйлчилгээний төлбөр	ш	1	1,050,000	1,050,000
Нийт дүн					1,050,000

----oOo----